


Үйлдвэрийн ажилтнуудад зориулсан мэдээлэл

www.aiche.org/ccps/process-safety-beacon

ТДХ хэмжигчийн зөвшөөрөгдөх заалт гэж юу вэ?

2022 оны 08 сар



Зураг 1. Дэлбэрэлт болон гал гарсны дараа

Устөрөгчийн сульфид (PPM)	Нүүрсстөрөгчийн хий (PPM)	Нүүрсстөрөгч (тэсрэх доод хязгаар %)	Хүчилтөрөгч (%)
10	213	67%	20.9

Хүснэгт 1. Материал хоослохын өмнө хийсэн, танк доторх хийн тестийн харуу

Вакум машин болон цахилгаан дамжуулдаггүй шланг ашиглан танк хоослох ажлын үед танк дэлбэрчээ. Ослоор дөрвөн гэрээт ажилтан амиа алдаж, нэг ажилтан ноцтой бэртсэн байна. Холбогдох компани болон гэрээт ажилтнууд 8 сая ам. долларын торгууль төлж, үйлдвэрийн үйл ажиллагаа хэдэн долоо хоногийн турш саатжээ.


Дээрх ажилтнууд танк дотор шатамхай уурын найрлага байгааг тооцоолоогүй. Ослоос өмнөх 10 орчим жилийн хугацаанд процессын өөрчлөлтийн улмаас танк дотор шингэний гадаргуу дээр шатамхай, шингэн нүүрсстөрөгч аажмаар хуримтлагдсаар байсан. Танк дотор шатамхай материал байгааг сэрэмжлүүлсэн хэд хэдэн осол тохиолдож байжээ.

Уг осолд нөлөөлсөн хэд хэдэн шалтгаан байгаа боловч энэ сарын дугаарт зөвхөн нэгийг нь онцлох болно. Оператор ажлын зөвшөөрөл бэлдэх зуур танк доторх “хийн заалт”-ыг шалгасан бөгөөд танкны дотор болон дээд амсарт ойрхон байрлах хийн заалт Тэсрэх Доод Хязгаарын 67% байжээ (Хүснэгт 1). Гэвч тэрхүү өндөр үзүүлэлтээс үл хамааран ажлыг цааш үргэлжлүүлсэн шалтгаан тодорхой бус байна. Тэсрэлт үүсгэсэн галын эх үүсвэр нь электростатик оч болон өөрөө авалцдаг материал байсан ба эдгээр эх үүсвэрүүдийн алийг нь ч ажилд бэлдэх үед тодорхойлоогүй байна.

<https://www.hse.gov.uk/comah/chevron-pembroke-report-2020.pdf>

Та мэдэх үү?

- АНУ-ын ХАБЭМА зэрэг зарим зохицуулагч агентлагууд шатамхай уурын концентрац Тэсрэх Доод Хязгаарын 10%-иас дээш байвал хязгаарлагдмал орчинд ажиллах зөвшөөрөл олгохыг хориглодог.
- Агаараас хүнд жинтэй шатамхай уур олон байдаг ба тэдгээр нь танкны ёроол, хонхор, шуудуу гэх мэт хамгийн доор байрлах цэгүүдэд ойрхон байх тусам концентрац нь ихэсдэг.
- Танкны ёроолд хуримтлагдсан лаг маш их хэмжээний тэсрэмтгий бодисыг агуулж байх боломжтой. Хуримтлагдсан лагыг хөндөх эсвэл цэвэрлэх үед тэсрэмтгий бодис гадагш алдагдаж болзошгүй.
- Шингэн бодис (зарим хатуу бодис ч бас) шлангаар урсах үед статик цэнэг үүсэх боломжтой. Аюултай байршилд байгаа эсвэл ойрхон буй бүх тоног төхөөрөмжийг холбож, газардуулах нь чухал.



Та юу хийж болох вэ?

- Зөв тохируулсан ТДХ хэмжигч болон ТДХ хэмжих журам ашиглан хийн тестүүдийг гүйцэтгэ.
- Хэмжилтийн заалт ТДХ хэмжих журамд тусгасан хязгаараас хэтэрсэн бол ямар нэгэн зүйл буруу байгааг илтгэдэг. Тухайн асуудал шийдэгдэх буюу зохих үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл ажлыг үргэлжлүүлж болохгүй.
- “Beacon”-ы 2020 оны 08 сарын дугаараас шатамхай бодисын тест хаана хийх тухай, 03 сарын дугаараас вакум машинтай холбоотой аюул эрсдлүүдийн тухай унш.
- Үйлдвэрийн талбайд танк цэвэрлэх үйл ажиллагаанд инженерийн шилдэг арга туршлагуудыг мөрдөх нь зүйтэй. Жишээ: Эрчим Хүчний Хүрээлэн, 16-р хэсэг “Танк Цэвэрлэх Аюулгүйн Дүрэм,” API 2015 “Түлш Хадгалах Танканд Аюулгүй Нэвтрэх болон Цэвэрлэгээ Хийх” гэх мэт.

ТДХ хэмжигчийн заалт агаарын найрлагад шатамхай бодис байгааг илтгэдэг.